

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

## Журам батлах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1."Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам"-ыг нэгдүгээр, Гэмт хэрэг зөрчлийн болон эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн иргэн, хуулийн этгээдийн лавлагаа авах байгууллагын жагсаалтыг хоёрдугаар, Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудасны загварыг гуравдугаар, Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /хошууч генерал Ж.Болд/, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /П.Сайнзориг/-д тус тус даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/195, 2018 оны А/03, А/116, 2019 оны А/197 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Х.НЯМБААТАР

Танилцсан:

Дэд сайд

Б.Солонгоо

Зөвшөөрсөн:

Төрийн нарийн  
бичгийн дарга

П.Сайнзориг

Хянасан:

Бодлогын хэрэгжилтийг  
зохицуулах газрын дарга

Э.Энхтуяа

Боловсруулсан:

БХЗГ-ын ахлах мэргэжилтэн С.Батзаяа

**МЭДЭЭЛЛИЙН САНД МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ШАЛГАХ,  
ҮНЭЛЭН ШИНЖЛЭХ, АШИГЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ, ХҮЛЭЭН АВАХ,  
ХУВААРИЛАХ, ҮР ДҮНГ ТООЦОХ, ЛАВЛАГАА ӨГӨХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журам нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэг зөрчил, ял шийтгэлийн мэдээллийн сан /цааш ид “Мэдээллийн сан” гэх/-д мэдээлэл цуглуулах, хүлээн авах, хуваарилах, цахим болон цаасан суурьтай сан үүсгэх, түүнээс лавлагаа өгөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цагдаагийн албаны тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомж, олон улсын гэрээ, холбогдох стандарт болон энэхүү журмыг мөрдөж ажиллана.

1.3.Энэхүү журмын 1.1-д заасан мэдээллийн санд мэдээлэл шилжүүлэх, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, үр дүнг тооцох, санд нэвтрэх эрх, хугацааг тодорхойлсон жагсаалт болон мэдээллийн сангийн аюулгүй байдлыг цагдаагийн төв байгууллагын даргын баталсан дотоод журмаар нарийвчлан зохицуулна.

1.4.Мэдээллийн сан нь цагдаагийн байгууллагын албаны нууцад хамаарна.

**Хоёр.Мэдээллийн санд мэдээлэл цуглуулж шалгах, ашиглах**

2.1.Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1-61.1.5, 61.1.7-61.1.9, 61.1.20 дэх заалтад заасан тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэж, үйл ажиллагаандаа ашиглана.

2.2.Цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь энэ журмын 2.1-д дурдсан тоо бүртгэлийг хөтөлж, баяжилт хөдөлгөөн хийнэ.

2.3.Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2 /ял шийтгүүлсэн/, 61.1.3 /эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан/, 61.1.4 /эрүүгийн хэрэг, үйлдэл холбогдол нь хэрэгсэхгүй болж цагаатгагдсан/, 61.1.5 /эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн/, 61.1.7 /өршөөл, уучлалд хамрагдсан хүмүүс/, 61.1.20 /эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хуулийн этгээд/-д заасан мэдээллийн сан бүрдүүлэх журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар батална.

2.4.Мэдээллийн санд нэвтрэх эрх бүхий алба хаагчдын сүлжээнд нэвтрэх эрх олгох, өргөтгөх, өөрчлөх, цуцлах үүргийг цагдаагийн байгууллагын мэдээллийн технологи хариуцсан нэгж гүйцэтгэнэ.

2.5.Мэдээллийн санд хандах эрх нь мэдээллийг бүртгэх, танилцах, хянах, засварлах, нөхөн бүртгэх, баталгаажуулах гэсэн төрөлтэй байна.

2.6.Цагдаагийн алба хаагч мэдээллийн санд хандалт хийхдээ зөвхөн өөрийн нэр, нууц үгээр системд нэвтрэх бөгөөд мэдээллийн санд мэдээллийг даруй үнэн зөв, бүрэн оруулах үүрэгтэй.

2.7.Цагдаагийн алба хаагчийн мэдээллийн санд оруулсан мэдээлэлд тухайн байгууллагын дарга, эрх бүхий алба хаагч хяналт тавьж, алдаатай оруулсан мэдээллийг зөвтгүүлэх арга хэмжээг даруй авна.

2.8.Мэдээллийн сан эрхэлсэн нэгж нь мэдээллийн санд оруулж байгаа мэдээллийг хянах, засварлах, нөхөн бүртгэх, баталгаажуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх үйл ажиллагаанд тус тус хяналт тавина.

2.9.Мэдээллийн санд мэдээллийг даруй оруулж, мэдээллийн сан үүсгэх, мэдээлэл цуглуулах ажлыг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг цагдаагийн байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгж, алба хаагч болон тухайн цагдаагийн байгууллагын дарга тус тус хүлээнэ.

2.10.Мэдээллийн сангийн ашиглалтын талаар хийсэн үйлдэл, хандалт зэрэг нь системд бүртгэгдэж байхаар бүртгэл /log/-ийг хөтлөхөөр зохицуулна.

### **Гурав.Мэдээллийг үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах**

3.1.Мэдээллийн сангийн мэдээллийг үнэлэн шинжлэхдээ дор дурдсан судалгаа, шинжилгээний ерөнхий аргыг ашиглана:

- 3.1.1.статистикийн;
- 3.1.2.ажиглалт хийх;
- 3.1.3.ярилцлага хийх;
- 3.1.4.таамаглал дэвшүүлэх;
- 3.1.5.зэрэглэл тогтоох;
- 3.1.6.загварчлалын;
- 3.1.7.ижил төсөөлөл харьцуулалтын;
- 3.1.8.системийн анализ гэх мэт.

3.2.Мэдээллийг шинжлэн үнэлэхдээ дараах чиглэлийг баримтална:

3.2.1.эрсдэл бий болох нөхцөл байдал, хор уршгийг тогтоож, мэдээлэл зэрэглэл тогтоох, түүнд дүн шинжилгээ хийх;

3.2.2.тухайн мэдээлэлтэй холбоотой эмзэг байдлын үнэлгээ хийх;

3.2.3.эрсдэлийг бууруулахад чиглэсэн хүч, хэрэгслийн чадавхын үнэлгээ хийх;

3.2.4.нөхцөл байдалд тулгуурласан мэдээллийн үнэлгээ хийх.

3.3.Мэдээллийг үнэлэн шинжлэх нь дараах хэлбэртэй байна:

3.3.1.судалгаа шинжилгээний чиглэлээр ашиглах;

3.3.2.дотоод үйл ажиллагааны чиглэлээр ашиглах;

3.3.3.байгууллагын дарга, холбогдох алба хаагчид танилцуулах;

3.3.4.дээд шатны байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх;

3.3.5.хойшлуулшгүй арга хэмжээ авхуулах;

3.3.6.даруй шийдвэрлэх шаардлагатай.

3.4.Мэдээллийн сан дахь шаардлагатай мэдээллийг цахим болон биет байдлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж болно. Энэ тохиолдолд нууцлал, аюулгүй байдлыг хангана.

3.5.Мэдээллийн сан болон дүн шинжилгээ, судалгааны асуудал эрхэлсэн нэгж нь энэхүү журмын 2.1-д заасан мэдээлэлд тулгуурлан болзошгүй нөхцөл байдал, үйл явцын талаарх урьдчилсан таамаглал, төсөөллийг боловсруулж, түүнд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах санал, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж болно.

### **Дөрөв.Мэдээллийг шилжүүлэх, хуваарилах, үр дүнг тооцох**

4.1.Энэхүү журмын 3.5-д заасан санал, зөвлөмжийг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

4.2.Энэхүү журмын 4.1-д заасны дагуу санал, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан зөвлөмжийн хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар статистик мэдээлэл болон дүн шинжилгээ, судалгаа хариуцсан нэгжид хүргүүлж болно.

4.3.Цагдаагийн байгууллагын ял шийтгэлийн мэдээллийн санг төрийн мэдээллийн нэгдсэн /ХУР/ системээр дамжуулан, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд эрх бүхий байгууллага мэдээллийн сан, сервер үүсгэн ашиглаж болно.

### **Тав.Мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл өгөх**

5.1.Цагдаагийн байгууллага нь хууль тогтоомжийн хүрээнд иргэн, хуулийн этгээдийн гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдсан болон шалгагдаж байгаа, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон байсан эсэхийг судлан үзэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу холбогдох лавлагааг гаргаж өгнө.

5.2.Дээрх лавлагааг энэхүү журмын 3, 4 дүгээр хавсралтаар баталсан загварын дагуу болон албан бичгээр олгоно.

5.3.Иргэн, хуулийн этгээдийн гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдсан, шалгагдаж байгаа, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон байсан эсэх лавлагааг тухайн иргэн, хуулийн этгээд өөрийн биеэр болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан цагдаагийн байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгж, мөн төрийн мэдээлэл солилцооны /ХУР/ системээс "Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл хариуцагчаас олгох лавлагаа, тодорхойлолтын загвар" маягтын дагуу авна.

5.4.Төрийн байгууллагад ажиллах иргэн, бүх шатны сонгуульд нэр дэвшигч, тусгай зөвшөөрөл хүсэж буй иргэн, хуулийн этгээд бүрдүүлэх материалдаа дээрх төрлийн лавлагааг өөрөө гаргаж өгнө.

5.4.1.Иргэн, аж ахуйн нэгж, нэр дэвшигчийн бүрдүүлсэн лавлагаа, мэдээлэлд эргэлзээтэй байдал тогтоогдвол тухайн матерайлыг хүлээж авсан байгууллага цагдаагийн байгууллагаас албан бичгээр нэмэлт лавлагаа, мэдээлэл авч болно.

5.4.2.Энэхүү журмын 5.4.1-д заасан нэмэлт лавлагаа, мэдээллийг цагдаагийн байгууллагаас авахдаа тухайн иргэн, хуулийн этгээд, нэр дэвшигчийн өөрийн урьд өмнө гаргасан лавлагаа мэдээллийг хавсарган ирүүлнэ.

5.5.Энэхүү журмын 5.1-д заасан мэдээллийг хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан бусдад задруулахыг хориглоно.

5.6.Иргэн, хуулийн этгээд өөрийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон байсан эсэх лавлагааг авахад цагдаагийн байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгж болон төрийн мэдээлэл солилцооны /ХУР/ системээс гарах маягтад дор дурдсан мэдээлэл /бичилт/-ийг тусгана.

5.6.1.Иргэнд олгох:

- а.Цагдаагийн ерөнхий газар;
- б.Тодорхойлолт /Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа /байсан/ эсэх тухай/;
- в.Иргэний бүртгэлийн дугаар;
- г.Иргэний харьяалал;
- д.Ургийн овог;
- е.Эцэг /эх/-ийн нэр;
- ё.Өөрийн нэр;
- ж.Эрүүгийн хариуцлага;
  - хүлээгээгүй
  - хүлээж байна
  - хүлээж байсан

5.6.2.Хуулийн этгээдэд олгох:

- а.Цагдаагийн ерөнхий газар;
- б.Тодорхойлолт /Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа /байсан/ эсэх тухай;
- в.Улсын бүртгэлийн дугаар;
- г.Регистрийн дугаар;
- д.Оноосон нэр;
- е.Хуулийн этгээдийн хэлбэр;
- ё.Эрүүгийн хариуцлага;
  - хүлээгээгүй
  - хүлээж байна
  - хүлээж байсан

5.6.3.Хэрэв иргэн, хуулийн этгээд нь эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон байсан, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, уучлагдсан, өршөөн хэлтрүүлэгдсэн, хэрэг нь хэрэгсэхгүй болж байсан бол ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн, уучилсан, ялаас өршөөн хэлтрүүлж, хэргийг хэрэгсэхгүй болгож байсан тухай мэдээлэл /шүүхийн нэр, огноо, шийтгэх тогтоолын дугаар, зүйл анги, ял, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ, эхэлсэн, дууссан огноо/-ийг тусгана.

5.6.4.Хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан болон гэмт хэргийн шинжгүй, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгож, хэргийг буцаасан тохиолдолд маягтад уг мэдээллийг тусгахгүй.

5.6.5.Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолтыг англи хэлээр гаргаж болох бөгөөд маягтад дараах мэдээлэл /бичилт/-ийг тусгана:

- а. Цагдаагийн ерөнхий газар;
- б. Тодорхойлолт /Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай/;
- в.Бүртгэлийн дугаар /Төрсөн он, сар, өдөр/;
- г. Иргэний харьяалал;
- д. Гадаад паспортын дугаар;
- е. Эцэг /эх/-ийн нэр;
- ё. Өөрийн нэр;
- ж. Эрүүгийн хариуцлага:
  - хүлээгээгүй
  - хүлээж байна.

5.7.Гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шатанд, түүнчлэн төрийн хяналт шалгалтын явцад дээрх төрлийн лавлагаа, мэдээллийг түүхчилсэн байдлаар энэхүү журмын хоёрдугаар хавсралтын “а”-д заасан байгууллагуудад олгох бөгөөд бусад тохиолдолд олгохгүй.

5.8.Иргэн, хуулийн этгээд зөрчлийн хэрэгт холбогдон шалгагдаж байсан лавлагааг олгохдоо Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааг баримтлан зөрчлийн хариуцлага хүлээж байсан эсэх лавлагааг олгоно.

### **Зургаа.Бусад**

6.1.Мэдээллийн сангаас мэдээлэл алдагдсан, утсан, өөрчилсөн тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.2.Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах үүргийг цагдаагийн төв байгууллагын мэдээллийн технологи хариуцсан нэгж холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцна.

---oOo---

Төсөл  
Хууль зүй, дотоод хэргийн сайдын  
2023 оны ..... дугаар сарын ....-ний  
өдрийн ..... дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

**ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН  
ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ИРГЭН, ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ЛАВЛАГАА АВАХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

а.Гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шатанд, түүнчлэн төрийн хяналт шалгалтын явцад дээрх төрлийн лавлагаа, мэдээллийг шууд авах эрх бүхий байгууллага.

1. Шүүхийн байгууллага;
2. Прокурорын байгууллага;
3. Авлигатай тэмцэх байгууллага;
4. Тагнуулын байгууллага;
5. Цагдаагийн байгууллага;
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага.

б.Шаардлагатай тохиолдолд хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөвхөн эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн иргэн, хуулийн этгээдийн лавлагаа, мэдээллийг нягтлах, нэмэлт мэдээлэл авах эрх бүхий байгууллага.

1. Төрийн албаны зөвлөл;
2. Монгол банк;
3. Сонгуулийн ерөнхий хороо;
4. Санхүүгийн зохицуулах хороо;
5. Улсын бүртгэлийн байгууллага;
6. Шүүхийн шинжилгээний байгууллага;
7. Олон улсын зэрэглэлтэй нисэх буудал;
8. Монголын хуульчдын холбоо;
9. Монголын өмгөөлөгчдийн холбоо;
- 10.Хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага.

Төсөл  
Хууль зүй, дотоод хэргийн сайдын  
2023 оны ..... дугаар сарын ....-ний  
өдрийн ..... дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт

**ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЖ БАЙСАН  
ЭСЭХИЙГ ШАЛГАХ ХУУДАС  
/Иргэн/**

.....оны ..... сарын ..... өдөр

.....аймаг, хот

1	Ургийн овог	
2	Эцэг /эх/-ийн нэр	
3	Нэр	
4	Төрсөн, он, сар, өдөр	
5	Төрсөн аймаг, хот, сум, дүүрэг	
6	Хүйс	
7	Яс үндэс	
8	Боловсрол, мэргэжил	
9	Төгссөн сургууль, эрхэлж байсан ажил /он дарааллаар бичнэ/	
10	Иргэний бүртгэлийн дугаар	
11	Урьд эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх	

Шалгасан тухай тэмдэглэл:

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

ГҮЙЦЭТГЭСЭН: ..... хэлтэс /тасаг/-ийн.....  
албан тушаалтай .....цолтой ..... / /

ХЯНАСАН:.....хэлтэс /тасаг/-ийн дарга ..... цолтой...../ /

ШАЛГАСАН:..... ажилтан /цол, нэр/..... / /

---оОо---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын  
2023 оны ..... дугаар сарын ....-ний  
өдрийн ..... дугаар тушаалын  
дөрөвдүгээр хавсралт

**ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЖ БАЙСАН  
ЭСЭХИЙГ ШАЛГАХ ХУУДАС  
/Хуулийн этгээд/**

.....оны ..... сарын ..... өдөр

..... аймаг, хот

1	Хуулийн этгээдийн нэр	
2	Улсын бүртгэлийн дугаар	
3	Регистрийн дугаар	
4	Байгуулагдсан огноо	
5	Үйл ажиллагааны үндсэн чиглэл	
6	Хариуцлагын хэлбэр	
7	Хаяг	
8	Шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны мэдээлэл	
9	Аль улсын харьяалалтай эсэх	
10	Өмчийн хэлбэр	
11	Урьд эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх	

Шалгасан тухай тэмдэглэл: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

ГҮЙЦЭТГЭСЭН: ..... хэлтэс /тасаг/-ийн.....  
албан тушаалтай .....цолтой...../ /

ХЯНАСАН:.....хэлтэс /тасаг/-ийн дарга ..... цолтой...../ /

ШАЛГАСАН:..... ажилтан /цол, нэр/..... / /

---оОо---